

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/33/НА/-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: azzayats@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ДЭЛГЭР ТАНАА

2022.02.09 № 2/10
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



021020139

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10415225.0</u>	<u>12454225.0</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10415225.0	12454225.0
354	Хангамжийн материал	10415225.0	12454225.0
35410	Бичиг хэргийн материал	280000.0	215000.0
35420	Аж ахуйн материал	2686600.0	2686600.0
35440	Түлш, шатах тослох материал	3200000.0	5304000.0
35470	Бусад хангамжийн материал	4248625.0	4248625.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>568560058.1</u>	<u>623757317.5</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	568560058.1	623757317.5
392	Биет хөрөнгө	562112458.1	617684717.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	527969913.7	527969913.7
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30731526.4	-43746237.5
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77000000.0	139000000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77000000.0	-80444444.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143618827.4	161565919.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	122389455.3	-130975792.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41662650.0	47519990.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29199195.9	-32624019.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	36454650.5	36454650.5
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5850406.0	-7827894.8
39217	Ном	577000.0	792632.0
393	Биет бус хөрөнгө	6447600.0	6072600.0
39301	Програм хангамж	1050000.0	1050000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-675000.0	-1050000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	6072600.0	6072600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>578975283.1</u>	<u>636211542.5</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8766.0</u>	<u>6172.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8766.0	6172.0
413	Өглөг	8766.0	6172.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8766.0	6172.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>578966517.1</u>	<u>636205370.5</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	578966517.1	636205370.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781939208.9	781939208.9
51101	Өмч: - төрийн	781939208.9	781939208.9
512	Хуримтлагдсан үр дүн	-	-167622173.1
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-224861026.5
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	57238853.4

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21888334.7	21888334.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	578975283.1	636211542.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	530780315.0	586396320.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9011315.0	74533020.0
120	Нийтлэг татварын бус орлого	9011315.0	74533020.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	8575695.0	74280724.0
1200046	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	435620.0	252296.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521769000.0	511863300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521769000.0	511863300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	521769000.0	511863300.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	537704314.0	529157466.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537704314.0	529157466.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525469791.0	514955228.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377645479.0	368851043.0
210101	Үндсэн цалин	266316879.0	266566314.0
210102	Нэмэгдэл	85667600.0	67207935.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13879138.0	13119733.0
210104	Урамшуулал	11781862.0	21957061.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47199750.0	47937146.1
210201	Тэтгэврийн даатгал	32095830.0	33149424.1
210202	Тэтгэмжийн даатгал	3775980.0	3696930.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3020784.0	2957543.2
210204	Ажилгүйдлийн даатгал	755196.0	739388.1
210205	Эрүүл мэндийн даатгал	7551960.0	7393860.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17824896.0	12381604.0
210301	Гэрэл, цахилгаан	4157096.0	4166604.0
210302	Түлш, халаалт	12915800.0	8215000.0
210303	Цэвэр, бохир ус	752000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	41059567.0	35299813.0
210401	Бичиг хэрэг	8643390.0	5805000.0
210402	Тээвэр, шатахуун	14289730.0	13366870.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12184707.0	10008947.0
210404	Ном, хэвлэл	105620.0	120296.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650000.0	720000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5186120.0	5278700.0
2105	Нормативт зардал	500000.0	500000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500000.0	500000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8000000.0	12260660.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	1481300.0
210604	Урсгал засвар	8000000.0	10779360.0
2107	Томилолт, зочны зардал	5762000.0	3726450.0

210702	Дотоод албан томилолт	5762000.0	3726450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2814984.0	3175708.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	651066.0	1350840.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216000.0	240000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1574450.0	1439850.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57300.0	67500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22000.0	44000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286000.0	0.0
210807	Газрын төлбөр	8168.0	33518.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24663115.0	30822804.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24663115.0	30822804.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12234523.0	14202237.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2500000.0	2785000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2500000.0	2785000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9734523.0	11417237.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9734523.0	11417237.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6923999.0	57238853.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6923999.0	57238853.4

төгрөгөөр

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-217,937,027.5	585,890,516.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-217,937,027.5	585,890,516.0
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	-6,923,999.0	-6,923,999.0
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-224,861,026.5	578,966,517.1
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-224,861,026.5	578,966,517.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-224,861,026.5	578,966,517.1
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	57,238,853.4	57,238,853.4
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.9	21,888,334.7	-167,622,173.1	636,205,370.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	521769000.0	511863300.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521769000.0	511863300.0

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521769000.0	511863300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	521769000.0	511863300.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	514632100.0	500123960.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514632100.0	500123960.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502397577.0	487706722.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377598000.0	368853043.0
210101	Үндсэн цалин	266269400.0	266568314.0
210102	Нэмэгдэл	85667600.0	67207935.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13879138.0	13119733.0
210104	Урамшуулал	11781862.0	21957061.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47199750.0	47937146.1
210201	Тэтгэврийн даатгал	32095830.0	33149424.1
210202	Тэтгэмжийн даатгал	3775980.0	3696930.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3020784.0	2957543.2
210204	Ажилгүйдлийн даатгал	755196.0	739388.1
210205	Эрүүл мэндийн даатгал	7551960.0	7393860.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16305300.0	16270604.0
210301	Гэрэл, цахилгаан	4157096.0	4166604.0
210302	Түлш, халаалт	11259004.0	12104000.0
210303	Цэвэр, бохир ус	889200.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	44503543.0	34982517.0
210401	Бичиг хэрэг	8278110.0	5608000.0
210402	Тээвэр, шатахуун	17553326.0	13366870.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12501707.0	10008947.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720000.0	720000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5450400.0	5278700.0
2105	Нормативт зардал	500000.0	500000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500000.0	500000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8000000.0	12260660.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	1481300.0
210604	Урсгал засвар	8000000.0	10779360.0
2107	Томилолт, зочны зардал	5762000.0	3726450.0
210702	Дотоод албан томилолт	5762000.0	3726450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2528984.0	3176302.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	651066.0	1351434.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216000.0	240000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1574450.0	1439850.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57300.0	67500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22000.0	44000.0
210807	Газрын төлбөр	8168.0	33518.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12234523.0	12417237.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2500000.0	1000000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2500000.0	1000000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9734523.0	11417237.9

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9734523.0	11417237.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7136900.0</u>	<u>11739340.0</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7136900.0	11739340.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7136900.0	11739340.0
2200	Дотоод эх үүсвэрээр	7136900.0	11739340.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7136900.0	11739340.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7136900.0</u>	<u>-11739340.0</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.0</u>	<u>0.0</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.0</u>	<u>0.0</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	511863300.0	500446062.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511863300.0	500446062.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510863300.0	499446062.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374598000.0	368853043.0
210101	Үндсэн цалин	263269400.0	266568314.0
210102	Нэмэгдэл	85667600.0	67207935.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15820300.0	13119733.0
210104	Урамшуулал	9840700.0	21957061.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52040100.0	47937146.1
210201	Тэтгэврийн даатгал	36620800.0	33149424.1
210202	Тэтгэмжийн даатгал	3854800.0	3696930.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3083900.0	2957543.2
210204	Ажилгүйдлийн даатгал	771000.0	739388.1
210205	Эрүүл мэндийн даатгал	7709600.0	7393860.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16305300.0	16270604.0
210301	Гэрэл, цахилгаан	4251100.0	4166604.0
210302	Түлш, халаалт	11550000.0	12104000.0
210303	Цэвэр, бохир ус	504200.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34993800.0	34982517.0
210401	Бичиг хэрэг	5608000.0	5608000.0
210402	Тээвэр, шатахуун	12413000.0	13366870.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11352800.0	10008947.0

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720000.0	720000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4900000.0	5278700.0
2105	Нормативт зардал	500000.0	500000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500000.0	500000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24000000.0	24000000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11000000.0	11000000.0
210602	Тавилга	2000000.0	2000000.0
210604	Урсгал засвар	11000000.0	11000000.0
2107	Томилолт, зочны зардал	4680600.0	3726450.0
210702	Дотоод албан томилолт	4680600.0	3726450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3745500.0	3176302.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1693100.0	1351434.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.0	240000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1648900.0	1439850.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67500.0	67500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.0	44000.0
210807	Газрын төлбөр	52000.0	33518.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.0	1000000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.0	1000000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.0	1000000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	511863300.0	500446062.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	511863300.0	500446062.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	511863300.0	500446062.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.0	21.0
620001	Удирдах ажилтан	2.0	2.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	15.0
620003	Үйлчлэх ажилтан	4.0	4.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.0	21.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3.0	3.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.0	9.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалтын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Азаяа 2022 оны 01 дүгээр сарын 11-нээс 2021 оны 01 дугаар сарын 31-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх нь “Монгол Улсад хүний эрх эрх чөлөөг хамгаалах хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн хараат бус хариуцлагатай иргэдийн итгэлийн хүлээсэн шүүх эрх мэдлийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монгол улсын үндсэн хууль, шүүхийн тухай хууль, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагаа болон шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын хэлтсээс 2021 оны 11 дүгээр сард хяналт шинжилгээ үнэлгээ хийж 4 зөвлөмж бүхий хяналт шалгалтын тайлан гаргасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 529,157.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5,291.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3968.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,236.2 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,454.2 мянган төгрөг болж 2,039.0 мянган төгрөгөөр буюу түлээ нүүрсний үлдэгдлээр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 46,594.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 252.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 44,808.1 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 12,454.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 834,405.6 мянган төгрөг, оны эцэст 920,425.7 мянган төгрөг болж 86,020.0 мянган төгрөгөөр өссөн нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс автомашин, тоног төхөөрөмж шилжүүлсэн, өөрийн хөрөнгөөр тавилга тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Тайлант онд 11,739.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 74,280.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, акталсан хөрөнгө байхгүй ба тайлант оны эцэст 920,425.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд ажиллагсад болон байгууллагад төлөх татварын 6,1 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 578,966.5 мянган төгрөг байсан оны эцэст 63,6205.3 мянган төгрөг болж тайлант онд 57,238.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 57,238.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 511,863.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 511,863.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 511,863.3 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 511,863.3 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 500,446.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 500,446.0 мянган төгрөгийг зарцуулж 11,417.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 500,446.0 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 569.1 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 954.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 4,102.9 мянган төгрөгөөр, цалин хөлс нэмэгдэл урамшлыг 5,744.9 мянган төгрөгөөр хэмнэж, урамшууллын зардлыг 12,116.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс нээж ашиглаагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа оруулсан, 1 мэдээллийг оруулаагүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн “6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор” гэсэн заалтыг зөрчин хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны сайтад байршуулаагүй тул залруулсан болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, алдаа зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,785.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Ажилчдад олгосон түлшний хөнгөлөлтийг үр дүнгийн тайланд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаар тайлагнуулж тоог залрууллаа. Харин уг асуудлын холбогдох хуульд нийцээгүй байх зөрчилд зөвлөмж өгөх нь нь зүйтэй гэж үзлээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагын түлш халаалтын зардлаас нүүрс худалдан авч ажилчдад түлээ, нүүрсний тусламж олгон түлш халаалтын зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3. “жинхэнэ хэрэгжилтийн”, мөн ажилчдад олгосон түлшний хөнгөлөлтөөс шимтгэл суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1.4 “аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого” гэсэн заалттай нийцээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Түлш халаалтын зардлыг үнэн зөв тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сум дахь сум дундын шүүх	1	1,785.0					0	0	1	1,785.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.АЗЗАЯА